



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/120

Хэрлэн сум

Цаг агаарт зориудаар нөлөөлөх
экспедицийн үйл ажиллагаанд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 2.1.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ой хээрийн түймрийн болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, түймэр унтраахад дэмжлэг үзүүлэх, газар тариалан, бэлчээрийн ургамлын ургалтанд шаардлагатай хөрсний чийг болон гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх, хуурайшилт, цөлжилтийг сааруулах зорилгоор аймгийн хэмжээнд цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх экспедицийн үйл ажиллагааны зардалд 10,000,000 (арван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3.Экспедицийн бэлтгэл бэлэн байдлыг хангаж, шаардлагатай үед цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж тухай бүр тайлагнаж ажиллахыг аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга (Б.Хэрлэнчимэг)-д үүрэг болгосугай.

4.Дээрхи зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Гамшгийн эрсдлийг бууруулах зардлаас санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Ж.Гантулга)- тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 12-ны
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Санхүүжилт олгох сар			Нийт үнэ /төгрөг/
		2024.03	2024.04	2024.06	
1	Экспедицийн үйл ажиллагааны зардал	3,000,000	3,500,000	2,500,000	10,000,000
	Дүн /төгрөг				10,000,000